



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 06 сарын 13 өдөр

Дугаар 350

Улаанбаатар хот

### ┌ Автомашины тоо, төрөл тогтоох тухай ┐

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоолын 5 дугаар заалт, Монгол улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Сангийн сайдын хамтарсан 2022 оны 95/260 дугаар тушаалаар баталсан "Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн албан ажлын хэрэгцээнд автомашин ашиглах нийтлэг журам"-ын 3.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Байгаль орчны салбарын үйл ажиллагааны онцлог, цар хүрээг харгалзан Байгаль орчин, аялал жуулчлалын яамны үндсэн үйл ажиллагаа, дотоод албан хэрэгцээнд ашиглах үйлчилгээний автомашины тоо, төрлийг хавсралтад зааснаар баталсугай.

2.Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Цогтгэрэлд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Холбогдох хууль тогтоомжийн дагуу байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор үйлчилгээний автомашин ашиглалтыг сайжруулах ажлыг зохион байгуулах;

2.2.Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн албан ажлын хэрэгцээнд автомашин ашиглах нийтлэг журмын хэрэгжилтийг хангах;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 4 дүгээр улиралд багтаан тайлагнах.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132001748

16-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2024 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн  
330 дүгээр тогтоолын хавсралт

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМНЫ ДОТООД АЛБАН АЖЛЫН ХЭРЭГЦЭЭНД  
АШИГЛАХ АВТОМАШИНЫ АНГИЛАЛ, ТОО, ТӨРӨЛ

| Д/д | Үндсэн ангилал                                          | Төрөл                                                                                                        | Тоо |
|-----|---------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------|-----|
| 1   | Үндсэн үйл<br>ажиллагаанд ашиглах<br>үйлчилгээний машин | Туулах чадвар сайтай хөдөө ажлын<br>автомашин (орон нутагт уул уурхай,<br>байгаль орчны хяналт шалгалт хийх) | 3   |
|     |                                                         | Хот доторх ажлын суудлын автомашин<br>(Нийслэл орчимд хяналт шалгалт хийх)                                   | 2   |
|     |                                                         | Хот доторх ажлын жижиг оврын автобус                                                                         | 1   |
|     |                                                         | Нийт автомашин                                                                                               | 6   |